| 89 | | 90. Засгийн газрын 2020-оны 9 дүгээр тогтоолын дагуу эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлаар илэрсэн хуулийн этгээдийн мэдээллийн зөрчлийг арилгах | - | Байгууллагын удирдлага санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадвар нэмэгдэн эд хөрөнгийн бүртгэлийн эмх цэгцгүй байдал, зөрчил арилна. | Хуулийн этгээд буюу 7 байгууллагын зөрчлөөс Бага сургууль татан буугдсан. 6 байгууллага хариуцлагын хэлбэр зөв болж хэрэгжсэн. | 100% |
| 90 | | 91. Засгийн газрын 2020-оны 9 дүгээр тогтоолын дагуу эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлаар илэрсэн тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгах | - | . | Нийт 21 тээврийн хэрэгслийн зөрчлөөс 2ш тээврийн хэрэгсэл акталсан, 5 мотоцикль 1 авто машины актлах санал ОНӨГ-т 10-р сард хүргүүлсэн. Одоогоор хурлын шийдвэр ирээгүй. Урьд ашиглаж байсан нэр шилжиж актлагдаагүй 2 авто машины 880,000 төгрөгийн татварын өртэй 2024 оны төсөвт тодотгол хийхээр төлбөрийг барагдуулж хасагдуулна.2ш мотоциклын өр төлбөрийг барагдуулахаар төсөвт зохицуулалт хийсэн ондоо багтаж авто тээврийн газраар хасалт хийлгэнэ.2 авто машины зөрчил огт арилаагүй. | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4 авто машин татварын програмд огт бүртгэлгүй байна. | |
| 91 | | 92. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх, хяналт тавих | - | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт хийгдэж, мэдээлэл нь бодиттой болсон байна. | Хүн амын өрхийн мэдээллийн сангийн өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр хийж урд оноос суурин хүн ам урьдчилсан байдлаар 38 хувиар буурсан (2022 оны жилийн эцэст 3800, 2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар 3762 хүн амтай) үзүүлэлтэй байна. Хүн амын үзүүлэлтийн 14, өрхийн 19 үзүүлэлтийг хянаж өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр хийсэн. 2023 оны 12 дугаар сарын 31-нд жилийн эцсийн хүн амын мэдээллийг эцэслэн гаргасан байна. | 100% |
| 92 | | 93. Тооллого, судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах | - | Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого, түүвэр судалгааг үр дүнтэй, чанартай зохион байгуулсан байна. | Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаанд малтай өрхийн 15% буюу 132 өрх (адуу-427, үхэр-165, тэмээ-2611, хонь-4596, ямаа-30869 нийт 38668 толгой мал) хамрагдаж дүн мэдээг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Мал тэжээвэр амьтад хашаа худгийн тооллогын ажлыг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/143 дугаар захирамжаар 8 чиглэлд 32 албан хаагч, хяналтын тоонд 4 албан хаагч томилогдон ажиллаж 2023 оны 12 дугаар сарын 14-ны байдлаар тооллого 80%-тай, шивэлт 31,2%-тай явагдаж байна. Жилийн эцсийн тооллогын дүн мэдээг 12 дугаар сарын 25-нд эцэслэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн байна. | 100% |
| 93 | Ес. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа | 94. Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэх | - | Сумын өвс, тэжээлийн нөөцийг зохих түвшинд бэлтгэн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 85-аас дээш хувиар хангасан байна. | Тус сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажилд ОНХС-н хөрөнгөөс 105,451,600 мянган төгрөгийг сумын ИТХ-аар батлуулж 2 удаагийн тендер зарласан боловч эхний удаа оролцогч ирээгүй, 2 дахь удаа 2 оролцогч ирсэн боловч шаардлага хангаагүй. Өвс 2000 боодол, ногоон тэжээл 2100 боодол, | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний салбарын хүрээнд: | | | | тэжээлийн будаа 1,2 тн, улаан хивэг 1800 ширхэг уутыг худалдан авахаар төлөвлөсөн байна.Малчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж 181тн өвс, 50,9тн хивэг, 63тн хужир, 17,9тн гар хадланг бэлтгэсэн байна. 2023 оны 11 сарын 14-ний өдөр 1300 боодол өвсийг худалдан авсан. | |
| 94 | | 95. Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах | - | Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. | Сумын бизнес эрхлэгчид 4220 мал нядалж зах зээлд борлуулан бэлтгэсэн.Мал мах 2023 аяны хүрээнд мал эмнэлгийн тасаг, сумын цагдаа, хэсгийн төлөөлөгч хамтран малаас гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавин ажилласан. | 90% |
| 95 | | 96. Малын үзлэг ангилалтыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгэх | 20,0 | Малын үзлэг ангилалтыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ. | Тус сумд үржүүлж байгаа Ламын гэгээний улаан үүлдрийн хэсгийн тэмээг ээмэглүүлж мал аж ахуйн нэгдсэн системийн мал бүртгэлийн программд бүртгэж оруулах ажлын хүрээнд 1800 тэмээг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж програмамд оруулж ажилласан. Мөн улсаас хавар намрын тэмээнд хянан магадлагааны комисс ирж ажилласан.<br><br>Хавсралт : 2 зураг | 90% |
| 96 | | 97. Хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах (хангайн сумууд) | - | Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан байна. | Говийн сум учир хамааралгүй заалт | 100% |
| 97 | | 98. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | 70,0 сая | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлсэн байна. | 2023 онд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхээр 2 гүний худаг гаргахаар төлөвлөн ОНХС-аас 70.0сая төгрөгийг зарцуулахаар сумын ИТХ-аар батлуулсан. Нээлттэй тендер зарлаж Чорьжбүрд компанитай гэрээ хийж тус сумын 2,4-р багийн | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутагт геофизикийн хайгуулыг хийж ус гарах цэгийг тогтоосон. | |
| 98 | | 99. Малын шилжилт-хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах | - | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулсан байна. | Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглосон аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20 өдрийн А/36 дугаар тоот захирамж, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31 өдрийн А/17 дугаар Захирамжыг тус тус хэрэгжүүлж ажиллаж байна. Мал мах-2023 аяны хүрээнд сумын хэсгийн төлөөлөгч, мал эмнэлгийн улсын байцаагч нар хамтран ажиллаж байна. Өвлийн идэшний цаг болсон тул мал нядалгааны газруудад очиж хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж мөн мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, бог малын мялзан өвчний талаар 3 өрхөд тандалтын судалгаа хийж ажилласан. Цагаан ямаат хоршооны малчдад мал эмнэлгийн үйлчилгээ, МЭНС-2.0, цагийн мэдээллийн талаар 02 дугаар сарын 06 өдөр Малын эмч Г.Ерөөлт, тархвар зүйч А.Элдэв-Очирын хамт оролцож 110 гаруй малчдад мэдээллийг өгч ажилласан. Малчид, төлчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж Мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийг 250 гаруй малчид хүргэсэн. Монгол ви ти нет олон улсын байгууллагатай хамтран 05-р сарын 07нд уяачид, малчидад зориулсан Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж эмийн худалдан борлуулалт хийгдсэн. | 100% |
| 99 | | 100. Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Улсын төсөв, Тамгын | Малын халдварт, гоц халдварт өвчин гараагүй байна. | Сумын хэмжээнд 81022 малыг халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх вакцинд хамруулахаар Мал эмнэлгийн тасгийн тархвар | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг үр дүнтэй зохион байгуулах | газраас 1,600,000 | | зүйч А.Элдэв-Очир мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж оруулсан. Баянлиг түмэн тэмээ мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 17686 толгой мал хамруулахаас 17367 толгой мал хамруулж гүйцэтгэл 98.20%, Баянлиг буянт сүрэг мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 27173 толгой мал хамруулахаас 26130 толгой мал хамруулж гүйцэтгэл 96.16%, Хар ботго мал эмнэлэг 8 төрлийн вакцинд 36163 толгой мал хамруулахаас 35932 толгой мал хамруулж гүйцэтгэл 99.36%-тай байна. Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 167757 толгой мал хамруулахаас 163290 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 97.34%тай хэрэгжүүлж ажилласан байна. Мөн гоц халдварт шүлхий өвчний вакциныг хавар, намрын давтамжтайгаар 2 удаа хийж гүйцэтгэсэн. Шатахууны зардалд Засаг даргын Тамгын газраас 1,600,000 төгрөг зарцуулсан. | |
| 100 | | 101. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг /Угаалга, Туулга, Боловсруулалт/ 20 сумын хэмжээнд нийт мал сүргийн 80% хамруулан чанартай зохион байгуулан ажиллах. | 1,600,000 | Аймгийн хэмжээнд 2.0 сая толгой малыг мал амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байна | Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 167757 толгой мал хамруулахаас 163290 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 97.34%тай хэрэгжүүлж ажилласан байна. | 100% |
| 101 | | 102. Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуй, мал эмнэлгийн салбарт хөрөнгө оруулалт хийх | 20,0 сая төгрөг | Татварын орлогын 70-аас доошгүй хувийг Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан арга хэмжээнд зарцуулсан байна | Ламын гэгээний улаан тэмээг үүлдэрээр баталгаажуулахад ОНХС 20.000,000 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж улсын хянан магадлагааны комисс 2 удаа тус сумд ирж ажилласан. | 90% |
| 102 | | 103. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх | - | Тариалалт ургац хураалтын төлөвлөгөөг | Тус сум нь 2023 онд төмс 6,8га талбайгаас 44,2тн, хүнсний ногоо 7,34га талбайгаас | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тариалалт ургац хураалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | | бүрэн хангасан байна. | 33,02тн, таримал тэжээлийн ургамал 5,4 га талбайгаас 9,2тн ургац хураан авсан.2022 оны тариалалттай харьцуулахад тэжээлийн ургамал 2,2 га талбайгаар илүү тариалж 31%-иар илүү ургац хураан авсан байна. | |
| 103 | | 104. Хоршооны тухай хуулийн 43.2-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах, Хоршоог хөгжүүлэх сангийн журмыг мөрдөх | 35,000,000 | Хоршоодыг чадавхжуулж, хөнгөлөлттэй зээлийн журмын хэрэгжилтийг хангаж сангийн хөрөнгийг тэргүүлэх салбарт олгож ажилласан байна. | Хоршоодыг чадавхжуулах талаар Баянхонгор аймгийн BEST хөтөлбөртэй хамтран сургалт мэдээллийг цахимаар зохион байгуулсан. Сургалтад 3 хоршооны төлөөлөл оролцсон. Хоршоо хөгжүүлэх сангаас Ахандүүсийн арвин ургац хоршоо 35,000,000 төгрөгийн хөнглөлтэй зээл авч малын тэжээлийн ургамал, төмс хүнсний ногоо, нарийн ногоо, хүлэмж зэргийг барьж сумын иргэдэд шинэ ургацын ногоогоор хангаж ажилласан. | 90% |
| 104 | | 105. Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээний үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хөтөлбөрийг орон нутгийн түвшинд 90%-тай хэрэгжүүлсэн байна | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор төсөл хэрхэн бичих, хөрөнгөө хэрхэн зөв зарцуулах талаарх сургалт мэдээлэл 2 удаа, мөн хуучин сургуулийн байранд өрөө гарган мужаан, эсгий гар урлал зэргээр иргэн, хоршоод үйл ажиллагаагаа явуулgh боломж нөхцөлөөр хангаж ажилласан. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн биелэлт 85 хувьтай. | 90% |
| 105 | | 106. Үйлдвэрлэл, үйлчилгээний объектуудад баталгаажуулалтын тогтолцоо бүрдүүлж мэдээллийн цахим санг ажиллуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах | - | Илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлж, хоол хүнсээр дамжих өвчин, хордлого халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авсан байна. | Сумын хүнс, барааны дэлгүүр цайны газраар сумын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл, цагдаагийн хэсэгтэй хамтран бараа бүтээгдэхүүний чанар болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар найман нэр төрлийн бараа бүтээгдэхүүний хугацаа дууссан байсныг газар дээр нь устгалд оруулж зөрчил гаргасан дэлгүүрүүдэд зөвлөмж хүргүүлж | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан | |
| 106 | | 107. Зориулалтын бус савыг хүнсний хэрэглээнд ашиглахгүй байх талаар соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, зориулалтын савны худалдаа, борлуулалтыг орон нутагт зохион байгуулах | 400,000 | Үзэсгэлэн худалдааг зохион байгуулж үр дүнг тооцсон байна. | Баялаг бүтээгчдийн” үзэсгэлэн худалдаа болж үзэсгэлэн худалдаанд 15 баялаг бүтээгч иргэн, 3 хоршооны төлөөлөл оролцсон. Тухайн үзэсгэлэн худалдаанд оролцогчид шинээр гарсан хууль тогтоомжоор мэдээлэл хийж мөн хүнсний зориулалтын сав баглаа боодолтой бүтээгдэхүүнийг шалгаруулж тухайн төрөлд Т.Баярмаагийн сүү, цагаан идээ хийх бүтээгдэхүүн шалгарч сумын Засаг даргын тамгын газраас дурсамж мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан | 100% |
| 107 | | 108. Хүнсний хувьсгал хөдөлгөөн, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэх, ажил арга хэмжээг зохион байгуулах | 400,000 | Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар хүнс үйлдвэрлэгч, иргэдэд нөлөөллийн ажил арга хэмжээг зохион байгуулсан байна. | Хүнс үйлдвэрлэгч иргэдийн дунд үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Уг үзэсгэлэн худалдаанд 13 иргэн 2 хоршоо, 1 ААН оролцсон. Тухайн үзэсгэлэн худалдаанд оролцогчид шинээр гарсан хууль тогтоомжийн талаар 75 иргэнд мэдээлэл хийж мөн шилдэг олон хүнсний бүтээгдэхүүнтэй оролцож байгаа оролцогчийг шалгаруулсан. | 90% |
| 108 | Арав. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд: | 109. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд иргэдэд Байгаль орчны салбарын хууль тогтоомжийн мэдлэг олгох | - | 5-аас доошгүй сургалт зохион байгуулж 1000-аас доошгүй иргэдийг хамруулсан байна. | Жил бүрийн 03 дугаар сарын 22-ний өдрийг Дэлхий усны өдөр хэмээн зарлаж тэмдэглэн ирсэн. Уг өдрийг угтан Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 ангийн сурагчид болон төрийн албан хаагч нарт эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт хийсэн ба 75 сурагч хамрагдсан. Тэрбум” мод арга хэмжээний хүрээнд төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд модоо тарьж эхлүүлье уриалга гарган ажилласан. Уриалгын хүрээнд албан байгууллагууд, иргэд мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн. Мөн сумын зарын нэгдсэн группээр дамжуулж 1200 хүнд мэдээлэл хүргэсэн. 2023 оны 05 дугаар сарын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 19 ний өдөр Монголын усны форм – Ус хэлтсийн хамт олонтой хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчид болон эко бүлгийн сурагчдад мод тарих аргачлалын талаар мэдээлэл хийж ажилласан. Нийт 250 сурагч хамрагдсан. | |
| 109 | | 110. Улсын болон орон-нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх | - | Сумын нутаг дэвсгэрийн тодорхой хувийг шинээр улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна. | Тус сумын газар нутгийн 45 хувийг Улсын тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг. Мөн орон нутгийн тусгай хамгаалалтад нийт 17 газар бүртгэлжүүлэн авсан бөгөөд мэдээллийн сангийн баяжуулалт хийж ажилласан. | 100% |
| 110 | | 111. “Тэрбум мод” тарих ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | - | Шинээр 25.0 мянган мод тарьсан байна ургалт 70-аас дээш хувьтай байна | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан.Ургалтын хувь 92,1 хувьтай байна. | 100% |
| 111 | | 112. Булгийн эхийг хашиж-хамгаалах тохижуулах ажлыг зохион байгуулах | - | Гол мөрний урсац нэмэгдсэн байна. | Баян-Ааргаг 2 дугаар багийн нутаг Хатавч, Бударгын булгуудын эх ундрагыг сэргээн засварлааж, булгийн эхийг тойруулан хамгаалалт хийсэн зэрлэг амьтад уух боломж нөхцөлийг сайжруулсан. | 90% |
| 112 | | 113. Ан амьтан, мал услах, газар тариалангийн усалгааны зорилгоор хөв | - | 1-ээс доошгүй хөв цөөрөм байгуулсан байна. | Баян-Ааргаг 2 дугаар багийн нутаг Хатавч, Бударгын булгуудын эх ундрагыг сэргээн засварлааж, булгийн эхийг тойруулан | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цөөрөм байгуулах | | | хамгаалалт хийсэн зэрлэг амьтад уух боломж нөхцөлийг сайжруулсан. | |
| 113 | | 114. Ундны усны эх үүсвэрүүдийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах | - | Улирал бүр шинжилгээнд хамруулсан байна. | 2023 онд Цагаан худаг, Цэргийн ангийн худаг, Цэвэрлэх байгууламжуудыг нийт 3 удаагийн усны шинжилгээнд хамруулсан. | 100% |
| 114 | | 115. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх | - | 2-оос доошгүй усны сан бүхий газрыг тэмдэгжүүлсэн байна. | Цагаан худаг – 50метр дотор эрүүл ахуйн бүс зөрчигдөөгүй Цэргийн ангийн худаг – 100 метр эрүүл ахуйн бүс зөрчигдөөгүй үзүүлэлттэй байна. | 100% |
| 115 | | 116. Усны сан бүхий газар болон усны эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсэд байгаа обьектыг чөлөөлүүлэх | - | Хамгаалалтын бүсэд байгаа 3,5 га газрыг чөлөөлүүлсэн байна. | Усны сан бүхий газар болон усны эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсэд байгаа обьект байхгүй болно | 100% |
| 116 | | 117. Зэрлэг амьтны идэш тэжээл хомсдож буй бүс нутагт биотехникийн арга хэмжээ авч амьдрах нөхцөлийг сайжруулах | - | 4-өөс доошгүй удаа биотехникийн арга хэмжээ авсан байна. | Энэ жилийн хувьд зэрлэг амьтад биотехникийн арга хэмжээ авах хүнд нөхцөл үүсээгүй болно. | 100% |
| 117 | | 118. Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах санхүүжилтийг шийдвэрлэх | 1,400,000 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Бороо хур муутай байсны улмаас цаг агаарт зориудаар нөлөөлөх буюу үүлэнд нөлөөлөх 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Генераторын түлш худалдаж авахад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 1,400,000 төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 118 | | 119. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн | - | Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах нөхцөл | Тус сумд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого ордоггүй болно. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | орлогыг хуулийн дагуу зарцуулах, хяналтыг сайжруулах | | бүрдсэн байна. | | |
| 119 | | 120. Нүхэн жорлонгийн тоог багасгаж, хөрсний бохирдлыг бууруулах | - | Нүхэн жорлонгийн тоог бууруулсан байна. | Тус сумд төвлөрсөн шугамд холбогдсон 6 төрийн байгууллага, 2 аж ахуйн нэгж, 100 өрх байна. 2023 онд стандартын бус 5 өрх, 2 аж ахуйн нэгжийн нүхэн жорлонг буулгаж шинэчлэх шаардлага хүргүүлэн хэрэгжүүлж ажилласан. | 100% |
| 120 | | 121. Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах | - | Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. | тус хөтөлбөрийн хүрээнд 2023 оны байдлаар сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэн 10.1 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай. | 90% |
| 121 | | 122. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, тогтолцоог нэвтрүүлэх | 30,000,000 | Иргэдийн цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Тус сумын Хатан суудал 5 дугаар багийн иргэн Ц.Цэндцэвэээн нь хоёрдогч түүхий эд болох хуванцар сав, гялгар уут, шил лааз, төмрийн хог зэргийг иргэдээс болон аж ахуйн нэгж байгууллагуудаас байнга авч эдийн засгийн эргэлтэд оруулж байна. 2023 онд жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн зээлийн үйлчилгээгээр пресслэгч машиныг 08 сард худалдан авч пресслэн эхлэсэн.Уг пресллэгч машин нь хуванцар савыг -25 кг, гялгар уут 50кг хүртэл пресллэх хүчин чадалтай. 2023 оны байдлаар Хуванцар сав- 3 тонн, гялгар уут – 4 тонн хаягдлыг иргэд болон аж ахуйн нэгж байгууллагаас авч пресслээд байна. Мөн төмрийн хог хаягдал бүхий 60 тонн хог хаягдлыг Улаанбаатар хотын хоёрдогч түүхий эд авах цэгт хүргүүлсэн. | 100% |
| 122 | | 123. Стандартад нийцсэн | - | 10-аас доошгүй хогийн сав | 2023 онд аж ахуйн нэгж байгууллага, | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хогийн савыг байршуулах | | байршуулсан байна. | дэлгүүрүүд гадна талдаа стандартын хогийн савыг байршуулсан. Нийт 12 хогийн сав шинээр байршуулсан. | |
| 123 | | 124. Бүх нийтийн цэвэрлэгээг сард 1 удаа, орчны цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа зохион байгуулах | - | Хоггүй цэвэр эрүүл орчин бий болгосон байна. | 2023 оны байдлаар сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэн 10.1 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн | 90% |
| 124 | | 126. Сумын гэр буудал, зоогийн газар, зочлох үйлчилгээний ажиллагсдыг сургаж чадавхжуулах | - | Зочлох үйлчилгээний чанар сайжирч, жуулчдын үйлчлүүлэх тав тухтай орчин бүрдүүлнэ. | Баянхонгор аймагт зохион байгуулагдсан гэр буудал, зоогийн газар, зочлох үйлчилгээний ажиллагсдыг сургаж чадавхжуулах сургалтад 3 хүн хамрагдсан. | 100% |
| 125 | | 127. Жуулчдын олноор очдог байгалийн өвөрмөц тогтоцтой газруудыг хамгаалах, тохижуулах | - | Аялал жуулчлалын нөөц газруудыг хамгаалж тохижуулсан байна. | 2020,2021 онуудад аялал жуулчлалын чиглэлээр Цагаан агуй, Бичигт хадыг тохижилтын ажил бүрэн хийгдсэн. | 100% |
| 126 | | 128. Эко аялал, явган аялал, дугуйн аялал, уулын аяллыг хөгжүүлэх холбоо, клубийг байгуулах. | - | Тоо: Байгуулсан холбоо, клубийн тоо Чанар: Аяллын төрөл хөгжсөн байх Хугацаа: Хагас, бүтэн жилээр тайлагнах | Аймгийн БОАЯЖ –ын газар, Соёлын төв, Ц.Нацагдоржийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуультай хамтран эко явган аялалыг жил бүрийн 09 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн Бямба гариг ахлах ангийн сурагчид залуу багш нарын дунд зохион байгуулахаар тогтсон. Энэ жил 32 багш, 10-12 дугаар ангийн 75 сурагчдыг оролцуулан эко аялал зохион байгуулсан. | 100% |
| 127 | | 129. Бичил уурхайн эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих | - | Байгаль орчныг хамгаалсан байна. | Тус сумд бичил уурхай байхгүй болно | 100% |
| 128 | | 130. Бичил уурхай эрхлэгч нөхөрлөлтэй гэрээ | - | Гэрээний биелэлтийг хангуулж бичил уурхай | Тус сумд бичил уурхай байхгүй болно | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах бүрд аймгийн Засаг даргын Тамгын газарт гэрээг хүргүүлэх | | эрхлэгчдэд хяналт тавьсан байна. | | |
| 129 | | 131. Ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавих | - | Байгалийн баялгийг зүй зохистой ашигласан байна. | Тус сумд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани байхгүй болно. Гар аргаар алт олборлох үйл ажиллагаанд Цагдаагийн хэсэгтэй хамтран 5 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. | 100% |
| 130 | | 132. Тухайн жил суманд ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төслийн талаар тухайн баг, орон нутгийн иргэдэд ил тод мэдээлэл өгөх | - | Иргэд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн талаар мэдээлэлтэй болсон байна. | Тус сумд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани байхгүй болно. | 100% |
| 131 | | 133. Улсын төсвийн хөрөнгөөр тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа геологийн судалгаа, зураглал, ерөнхий эрлийн төслүүдийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжих | - | Геологийн судалгаа, зураглал, ерөнхий эрлийн төслүүдийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна. | 1990 онд анх хийгдэж байсан геологийн судалгааны ажил 2 дахь жилдээ үргэлжилж байна. Уг судалгааны ажил Цагаан агуйд хийгдэж байгаа бөгөөд Соёлын яамнаас зохион байгуулалттай Герман,ОХУ болон Шинжлэх ухааны яамны судлаачид хэрэгжүүлж байна. | 70% |
| 132 | Арван нэг. Газрын харилцаа, дэд бүтцийн хүрээнд: | 135. Сум, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг эхлүүлэхдээ барилга эхлүүлэх зөвшөөрөл авч, захиалагчийн техникийн хяналтын гэрээ байгуулж, | - | Барилга, техникийн хяналтын зөрчлийг бууруулсан байна. | Шинээр баригдсан барилга байхгүй учраас энэ ажил хийгдээгүй | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үе шатны ажлуудад хяналт хийлгэх, дүгнэлт гаргуулах | | | | |
| 133 | | 136. Аймгийн Засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж орлогыг нэмэгдүүлэх | - | Цахимжуулалтыг бүрэн хийж, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. | Тус сумын газрын төлбөр 7,7 сая төгрөг төвлөрөхөөс 4,948,401 төгрөг төлөгдөж 53,2%-ийн биелэлттэй байна. Газрын албанаас олгосон газар эзэмших ашиглах эрхийн нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. | 70% |
| 134 | | 138. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалж хамгаалах, бүрэн бүтэн байдлыг хангаж тооллого хийх | - | Геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллогыг хийж тайланг хүргүүлсэн байна. | Тус сумд Геодезийн байнгын 17 цэг тэмдэгт байдаг. Үүнээс 5-р багийн нутаг дэвсгэрт 8, 4-р багийн нутаг дэвсгэрт 1, 3-р багийн нутаг дэвсгэрт 7, 2-р багийн нутаг дэвсгэрт 1 цэг тус тус байдаг. Тооллогоор бүгд бүрэн бүтэн байсан. | 100% |
| 135 | | 139. Газар зүйн нэрийн тодруулалт хийх | - | Сумын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | Газарзүйн нэрийн тодруулалт хийх ажлыг 2024 оны төлөвлөгөөнд оруулахаар ажиллаж байна. Аймгийн Газрын албанаас хуралд оруулахдаа санал материал оруулаагүй учир энэ ажил хийгдээгүй. | 0% |
| 136 | Арван хоёр. Хөрөнгө оруулалтын салбарын хүрээнд: | 140. Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг хууль журмын дагуу боловсруулан иргэд, олон нийтийн саналыг авч, эрэмбэлэн холбогдох хэлтэст ирүүлэх | - | 2023 онд Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон байна. | ОНХС-н 2024 онд хийгдэх ажлын санал боловсруулах, эрэмбэлэх ажлын хэсэг Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/30 дугаар захирамжаар байгуулагдаж, багийн дарга нарт саналын хуудсыг бэлтгэн хүргүүлж, багийн дарга нар саналаа авч нэгтгэн ИНХ-р батлан албан тоотоор ЗДТГ-т ирүүлсэн. Аймгийн ОНХС-н хөрөнгө оруулалтаар хуучин сумын төврүү дулааны шугам татах саналыг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулалтын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн. | |
| 137 | | 141. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөх, иргэдээс санал авах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, мэдээллээр хангах | - | Төсвийн ил тод байдал хангагдсан байна | 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 30 төсөл арга хэмжээнд иргэдийн санал авсан. ОНХС,ОНХС-ын удирдлага мэдээллийн систем гэсэн 2 тусгай цэсийг нээн Bayanlig.bkh.gov.mn вэб сайтад байршуулсан.Иргэд олон нийт вэб сайтруу хандан мэдээлэл авах боломжтой болсон.ОНХС-аппликшнаар санал хэрхэн өгөх талаар 5-р багийн Засаг дарга,хүний нөөцийн ажилтантай хамтран албан байгууллагуудад сургалт мэдээлэл хүргэсэн. | 100% |
| 138 | | 142. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд холбогдох мэдээллийг тухай бүр оруулах | - | Төсвийн ил тод байдал хангагдсан байна. | Onhs.mof.gov.mn -нд удирдлага мэдээллийн системд нийт ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөтөлбөр арга хэмжээний явц болон гүйцэтгэлийг зургаар баталгаажуулан оруулсан. Мөн ОНХС-н санхүүжилтээр хийгдэх тендер зарлагдахгүй шууд гэрээгээр явагдах ажлуудыг сумын цахим групп-т зар байршуулж үнийн саналыг авч шалгарсан иргэн аж ахуй нэгжтэй гэрээг байгуулж ажилласан. ОНХС-н санхүүжилтээр хийгдсэн ажлын гүйцэтгэлийг сумын вэб хуудсанд иргэдэд ил тод нээлттэйгээр мэдээ мэдээллийг хүргэн ажилласан. | 100% |
| 139 | | 143. Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумын хөгжлийн индексийн мэдээллийг 2022 оны байдлаар шинэчилж оруулах; www.ldi.nda.gov.mn. | - | Аймгийн хөгжлийн индексийг тодорхойлсон байна. | Тус сумын хөгжлийн индексийг 2022 оны жилийн эцсийн байдлаар 2023 оны 5-р сард мэдээлж Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст сумын Засаг даргын 2023.05.29-ний өдрийн 157 тоотоор мэдээллийг хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 140 | | 144. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Нээлттэй Баянхонгор аймаг“ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Шилжин ирсэн иргэдийн тоо ............ Шинэ сэргэлтийн бодлого, Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого, “Нээлттэй Баянхонгор аймаг“ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна. | Энэ онд Улаанбаатар хотоос шилжиж ирсэн хүн байхгүй. Шилжиж ирсэн хүмүүсийг тогтвор суурьшилтай ажиллах ажлын байраар хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Шинээр төгсөж буй оюутан сурагчдыг сум орон нутагтаа ажиллахыг уриалан дэмжиж 1 оюутны төлбөрийн тодорхой хувийг Засаг даргын Тамгын газраас гарган төгсөөд сумдаа ажиллах гэрээтэйгээр суралцуулсан. | 30% |
| 141 | Арван гурав. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд: | 145. Батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангах | 1700000 | Орон нутагт батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сурталчилснаар иргэдийн цэргийн үүргийн биелэлт дээшилнэ. | Сумын хэмжээнд цэргийн бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулж тэр үеэр иргэдийн дунд тэмцээн уралдаануудыг зохион байгуулсан ба иргэдэд Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулсан ба давхардсан тоогоор нийт 300 гаруй иргэдэд мэдээлэл хүргэсэн. Цэрэг татлагын үеэр цэргийн насны залуучуудад цэргийн албаны тухай хуулийн талаар танилцуулга бэлтгэн хүргэсэн. 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний ойн баяр, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Энхийг сахиулагчдын баярыг тохиолдуулан Зэвсэгт хүчний 103 дугаар тусгай салбартай хамтран иргэдэд Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхийн тулд марш тактикийн тэмцээн, буудлагын тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан. Ингэснээр иргэд батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэг чадвар дээшилсэн. | 100% |
| 142 | | 146. Цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах, мэдээ, судалгаа, тайланг | 500000 | Цэргийн бүртгэл судалгааны нэгдсэн тогтолцооны чанар | Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/06 дугаар | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ирүүлэх | | дээшилсэн байна. | захирамжаар байгуулан 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд зохион байгуулж явуулан мэдээ судалгааг цаг хугацаанд нь аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгсөн.<br><br>Хавсралт : 1 зураг | |
| 143 | | 147. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж хяналтын тоог биелүүлэх | 370000 | Цэрэг татлагын хяналтын тоо биелэгдэнэ. | сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/112 дугаар захирамжаар 2023 оны 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг халалт, татлагын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. 2023 оны цэрэг татлагаар 6 цэрэг тэнцэж ангиуддаа хувиарлагдан албаа хааж байна.<br><br>Хавсралт : 2 зураг | 100% |
| 144 | | 148. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сум, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулах | 7000000 | Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох оролцоо сайжирна. | Цэргийн дүйцүүлэх алба хааж буй иргэдийг сумын хэмцээнд 2 удаа дуудан 2-р багт цас их орж зам даваа хаагдсаныг нээх ажилд татан оролцуулсан. Мөн аймгийн Цэргийн штабтай хамтран 2023 оны 05 дугаар сард сумын хуучин барилгуудыг нураах ажилд цэргийн дүйцүүлэх албаны 40 албан хаагчийн 10 хоног ажиллуулсан. | 100% |
| 145 | Арван гурав. Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг | 149. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр төлөх иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | | Мөнгөн төлбөрийн орлого нэмэгдэнэ. | Мөнгөн төлбөр тогтоосон 4 иргэдээс 2 иргэн мөнгөн төлбөрөө бүрэн төлж 2 иргэн мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн болно. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд: | | | | | |

..............................oOo.............................